3. Төр, иргэний нийгмийн байгууллагын түншлэлийг бэхжүүлж, шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, зөв бодлогыг хэрэгжүүлэх
4. Төрийн албаны хүний нөөцийг үе шаттай сургаж, мэргэшүүлэн төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл боломжийг сайжруулж, төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөг дээшлүүлэх.
5. Төрийн байгууллагад хандсан иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг цахимаар хүлээн авч шуурхай шийдвэрлэх боломжийг бүрдүүлэх
6. Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг сайжруулах.
7. Төрийн бүх шатанд авлигаас урьдчилан сэргийлэх олон талт арга хэмжээнүүдийг зохион байгуулах.
8. “Чанарын менежментийн тогтолцоо MNS ISO 9001:2016” олон улсын стандарт”-ыг нэвтрүүлэх, сайжруулах
9. Төрийн байгууллагын албан хаагчдыг гадаад болон дотооддоо туршлага судлах арга хэмжээнд хамруулах, тасралтгүй хөгжүүлэх
10. Төрийн байгууллагуудын архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулах, баримт бичгийн эмх цэгцийг төлөвшүүлэх
11. Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх
12. Сумын гамшгийн эрсдэлийн үнэлгээ, тойм судалгааг холбогдох мэргэжлийн байгууллагаар хийлгэх, гамшгаас хамгаалах багаж, техник тоног төхөөрөмжийг сайжруулах
13. Цахим шилжилтийн төрийн үйлчилгээг орон нутагт үр дүнтэй, хүртээмжтэй хэрэгжүүлэхэд бүх талын нөхцөл, боломжийг бүрдүүлж ажиллах

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Монгол улсын үндсэн хууль, Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Архив бичиг хэргийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, НББ-ийн тухай хууль болон бусад тогтоол шийдвэрийг мөрдөн ажилласан байна.

Мөн Засгийн газрын "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 2021 оны 43 дугаар тогтоолоор төсвийн захирагч нарт төсвийг хэмнэлттэй зарцуулах үүрэг өгч ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй, аймгийн Засаг даргын 2020 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн А/424 тоот захирамжаар баталсан НБББББ-ийг мөрдөн ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бүрэгхангай сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй, аймгийн Засаг даргын 2020 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн А/424 тоот захирамжаар баталсан НБББББ-ийг мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Бүрэгхангай сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,242.3 сая төгрөгөөр буюу 63 хувиар буурсан байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авллага	1,266,838.1	1,051,686.7	/215,151.3/
Бараа материал	293,455.2	32,175.4	/261,279.8/
Үндсэн хөрөнгө	6,872,065.1	4,230,548.3	/2,641,516.8/
<b>Нийт хөрөнгө</b>	<b>8,783,766.9</b>	<b>5,541,396.7</b>	<b>/3,242,370.2/</b>
Өр төлбөр	12,560.3	78,785.3	66,225.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	8,771,206.6	5,462,611.4	/3,308,595.2/
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>8,783,766.9</b>	<b>5,541,396.7</b>	<b>/3,242,370.2/</b>

Дээрх хүснэгтээс харахад, 2022 он өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн дансны талаар товч тайлбарлан бичнэ.

Үндсэн хөрөнгө 2,641,5 сая төгрөгөөр буурсан нь ЭМТ, Соёл, Сургууль Цэцэрлэгийн байгууллагууд орон нутагт нэгтгэгдэхээ больж улсын төсөвт шилжсэнтэй холбон үзэж байна.

#### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 1,240.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 1,051.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнаж өмнөх оноос 188.5 сая төгрөгөөр буурсан байна.

#### Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Кассад байгаа бэлэн мөнгө</b>			
<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>			
<b>Төгрөг</b>	<b>1,266,838.1</b>	<b>1,051,686.7</b>	<b>-215,151.2</b>
Төрийн сангийн харилцах	1,240,267.9	1,051,686.7	-188,581.2
Арилжааны банк дахь харилцах			
Нэмэлт санхүүжилтийн харилцах	26,570.1		-26,570.1
<b>Гадаад валют</b>			
Арилжааны банк дахь харилцах			
Замд яваа мөнгөн хөрөнгө			
<b>Дүн</b>	<b>1,266,838.1</b>	<b>1,051,686.1</b>	<b>-215,151.2</b>

Эх сурвалж: Мөнгөн хөрөнгийн 2022 оны санхүүгийн нэгдсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 1,051.6 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд үлдэгдэлтэйгээр тайлагнажээ.

**Аудитын илрүүлэлт**

Мөнгөн хөрөнгөтэй холбоотой "Хос Хас" ХХК-иас ахмадын баярт 12 сая төгрөгийн хандив өгөхөөр төлөвлөж байсан ч тухайн үед шилжүүлээгүй тул ОНХС-аас ахмадын баярт шилжүүлж дараа нь М.Батцэнгэл Санхүүгийн албан даргын дансаар дамжуулж нөхөж хийсэнд зөвлөмж өглөө.

**3.5.2 Авлага**

Авлагын эхний үлдэгдэл 351.4 сая төгрөгийн, эцсийн үлдэгдэл 226.9 сая төгрөг болж 124.4 сая төгрөгөөр буурсан нь ЭМТ, Цэцэрлэг, Сургууль, Соёлын төв гэсэн байгууллагууд санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдээгүй хасагдсантай холбоотой байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага			
Төлбөртэй үйлчилгээний авлага	88,565,000	0	-88,565,000
Татаас, санхүүжилтийн авлага			
Зээлийн хүүгийн авлага			
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/			
Татаас, санхүүжилтийн авлага			
Байгууллагаас авах авлага	103,027,693	15,177,900	-87,849,793.00
Хувь хүмүүсээс авах авлага	159,815,800	211,808,403	51,992,603.00
Дүн	351,408,493	226,986,303	-124,422,190

Эх сурвалж: Авлагын 2022 оны санхүүгийн нэгдсэн тайлан

Дээрх авлагаас сумын ерөнхий орлогын дансанд 15.1, ХХС-гийн данст 193.6, ЖДҮДС-гийн дансанд 10.02, ОНХС-гийн дансанд 7.0, ЗДТГ 1.1 сая төгрөгийн авлагууд тус тус эзэлж байна.

Дээрх авлагаас ЖДҮ-ийг дэмжих сангаас 10.02 сая төгрөгийн авлага нь төлөгдөх эзэн нь тодорхойгүй авлагын үлдэгдэлтэй тайлагнасан зөрчилд зөвлөмж хүргүүлж ажиллалаа.

**Аудитын илрүүлэлт**

ЖДҮ-аас 10,022,085 төгрөгийн зээл авсан иргэдийн нэрсийг тодруулж арга хэмжээ авч ажиллах зөвлөмж өгсөн.

**3.5.3 Урьдчилгаа**

Урьдчилгаа төлбөртэй холбоотой дансны авлага өглөг үүсээгүй болно.

**3.5.4 Бараа материал**

Бараа материалын эхний үлдэгдэл 293.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 32.2 сая төгрөг болж, 261.3 сая төгрөгөөр буурсан нь ЭМТ, Соёл, Сургууль Цэцэрлэгийн байгууллагууд орон нутагт нэгтгэгдэхгүй болсонтой холбоотой байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал			
Тусгай зориулалттай материал	12,930,792.2	0	-12,930,792.2
Эм боох материал	59,822,757.65	0	-59,822,757.65
Дуусаагүй үйлдвэрлэл	0	0	0
Бэлэн бүтээгдэхүүн	0	0	0

<b>Хангамжийн материал</b>			
Бичиг хэргийн материал	3,067,250	431,400	-2,635,850
Аж ахуйн материал	159,564,302.94	770,000	
Сэлбэг хэрэгсэл	4,205,000	0	-4,205,000
Түлш, шатах тослох материал	2,020,000	0	-2,020,000
Барилгын засварын материал	2,948,000	0	-2,948,000
Хүнсний материал	13,992,054.8	0	13,992,054.8
Бусад хангамжийн материал	33,435,113	30,974,000	-2,461,113
<b>Мал амьтад</b>	<b>1,470,000</b>	<b>0</b>	<b>1,470,000</b>
<b>Дүн</b>	<b>293,455,270.59</b>	<b>32,175,400</b>	<b>-261,279,870.59</b>

Эх сурвалж: Бараа материалын 2022 оны санхүүгийн нэгдсэн тайлан

Тайлант онд бараа материалыг төсвийн хөрөнгөөр 50.9 сая төгрөгөөр худалдан авч, үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 2.4 сая төгрөгийн бараа материалыг тус тус орлого авч тайлагнажээ.

#### Аудитын илрүүлэлт

Сумын ТТЗ-ийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангаар ОНХС-гийн 2022 оны төлөвлөгөөнд тусгагдаагүй Соёлын төвд 1,000,000 төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсанд зөвлөмж өгөв.

#### **3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө**

Бусад эргэлтийн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэлгүй болно.

Хүснэгт 6. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
			Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад
Дүн			

Эх сурвалж: .....

#### Аудитын илрүүлэлт

#### **3.5.6 Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 8,427.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 5,502.9 сая төгрөг болж, 2,924.5 сая төгрөгөөр буурсан нь ЭМТ, Соёлын төв, сургууль, цэцэрлэг гэсэн төсөвт байгууллагууд салбар, салбарын нэгдсэн тайланд нэгдсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
			<b>Биет хөрөнгө</b>
Барилга, байгууламж, орон сууц	5,556,354.2	3,155,148.8	-2,401,205.3
Авто-тээврийн хэрэгсэл	325,737.9	206,279.5	-119,458.4
Машин тоног төхөөрөмж(компьютер)	983,343.4	659,432.5	-323,910.8
Тавилга, аж ахуйн эд хогшил	302,776.3	35,631.5	-267,144.7
Бусад үндсэн хөрөнгө	294,071.6	576,393.8	282,322.2
Зам гүүрний байгууламж	845,832.7	850,832.7	5,000.0
Дуусаагүй барилга, байгууламж			
Номын фонд	27,947.5	0	-27,947.5
<b>Биет бус хөрөнгө</b>			
Программ хангамж	13,650.0	8,600.0	-5,050.0

Бусад биет бус хөрөнгө	77,799.9	10,630.0	-67,169.9
<b>Бусад хөрөнгө /ТӨҮГ/</b>			
Хойшлогдсон татварын хөрөнгө /ТӨҮГ/			
Бусад эргэлтийн бус хөрөнгө /ТӨҮГ/ + Бусад			
<b>Дүн</b>	<b>8,427,513.7</b>	<b>5,502,949.1</b>	<b>-2,924,564.6</b>

Эх сурвалж: Үндсэн хөрөнгийн 2022 оны санхүүгийн нэгдсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 254.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж, 716.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг балансаас баланст шилжүүлэн авч, 3.0 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй буюу хандиваар орлого авч бусад хөрөнгө 3.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нийт 978.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 3,902.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хассанаар тайлагнасан нь эрүүл мэнд соёлын байгууллагууд нь харьяа салбартаа нэгтгэгдсэнтэй холбоотой байна.

Дуусаагүй барилга дансанд үлдэгдэл хөрөнгөгүй байна.

**Аудитын илрүүлэлт:**

"Ану сервис" ХХК нь цэвэр бохирын шугам тавьж дууссан ч 2022 ондоо багтааж хүлээж аваагүй гүйцэтгэгч компанид 75.0 сая төгрөгийн өглөгийг барагдуулаагүй тул зөвлөмж өгч ажиллаа.

**3.5.7 Өр төлбөр**

Нийт өр төлбөрийн дансны эхний үлдэгдэл 12.5 сая төгрөгийн, эцсийн үлдэгдэл 78.7 сая төгрөг болж, 66.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	/ мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Татварын өглөг			
Байгууллагад төлөх өглөг	0	78,785.3	78,785.3
Ажилчидтай холбоотой өглөг	12,560.3	0	12,560.3
Бусад			
<b>Дүн</b>	<b>12,560.3</b>	<b>78,785.3</b>	<b>66,225.1</b>

Эх сурвалж: Өр төлбөрийн 2022 оны санхүүгийн нэгдсэн тайлан

Дээрх өглөгийг ОНХС-ын "Ану сервис" ХХК нь цэвэр бохирын шугам тавьж дууссан ч 2022 ондоо багтааж хүлээж аваагүй гүйцэтгэгч компанид 75.0 сая төгрөгийн өглөгийг барагдуулаагүй өглөгийг санхүүгийн тайланд үлдэгдлээр тайлагнасан байна.

Урт хугацаат өр төлбөрийн данс үлдэгдэлгүй болно.

**Аудитын илрүүлэлт:**

Өглөгтэй холбоотой зөрчилгүй

**3.5.10 Засгийн газрын хувь оролцоо**

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 5910.8, эцсийн үлдэгдэл 1659.0 сая төгрөг болж 4251.8 сая төгрөгөөр буурсан нь Эрүүл мэнд, соёл, боловсролын байгууллагууд нь харьяа салбартаа нэгтгэгдсэн холбоотой байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	/ мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)

Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	8,771,206.6	5,462,611.4	-3,308,595.2
Өмч /төрийн/ /ТӨҮГ/			
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/			
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>5,144,540.4</b>	<b>3,868,846.3</b>	<b>-1,275,694.1</b>
Өмнөх үеийн үр дүн	4,101,399.5	6,940,318.5	2,838,918.9
Тайлант үеийн үр дүн	1,043,140.9	-3,071,472.2	-2,028,331.3
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,304,636.7	866,779.4	-1,437,857.3
Дүн	13,915,747.1	9,331,457.7	-4,584,289.3

*Эх сурвалж: Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 8,771.2, эцсийн үлдэгдэл 5,462.6 сая төгрөг болж 3,308.6 сая төгрөгөөр буурсан нь эрүүл мэнд, сургууль, цэцэрлэг, соёлын байгууллагууд нь харьяа салбартаа санхүүгийн тайлангаа нэгтгүүлсэнтэй холбоотой байна.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл өмнөх оноос 866.7 сая төгрөг болж 1,437.8 сая төгрөгөөр буурсан нь орон нутгийн байгууллагуудаас бусад байгууллагуудын хөрөнгийн дахин үнэлгээ салбарууддаа шилжиж тайлагнасантай холбоотой болно.

Эздийн өмчийн бусад хэсэг дансны үлдэгдэлгүй болно.

Хуримтлагдсан үр дүн 3,868.8 сая төгрөг болж 1,275.7 сая төгрөгөөр буурсан нь бүтцийн өөрчлөлтөөр хөрөнгө хасагдаж тайлагнасантай холбон үзэж байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн орлогоос 1,115.3 сая, үйл ажиллагааны орлогоос 650.0 сая, нийт зарлагыг 3,236.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Аймгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэг 46.8 сая төгрөгөөр төлөвлөж Төсвийн төслийн саналыг 3,236.7 сая төгрөгөөр өгч төсвийг 3,236.7 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй төлөвлөсөн болно.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант оны батлагдсан төсвийг 726.1 сая төгрөгөөр бууруулж тодотгосон байна. Орон нутгийн төсвөөс 1,629.5, үйл ажиллагааны орлого 430.3 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,544.3 сая төгрөг буюу 99 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардал болон хөрөнгийн зардлын төсвийг 462.3 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Тайлант хугацааны авлага 16.2 сая төгрөг болж өссөн нь 1995 оноос хойш эзэн холбогдогч нь тодорхойгүй олон жил он дамжсан авлага 1.1 сая төгрөг, цахим худгийн усны болон карт борлуулсан орлого 9.7 сая төгрөг, өвс тэжээл борлуулсан орлого 0.9 сая төгрөг, оны өмнө гүйлгээ хаахтай зэрэгцэн орж ирсэн отрын малчин өрхөд төрийн үйлчилгээг үзүүлэх дэмжлэг 1.5 сая төгрөг, сумын дотуур байрны өргөтгөлийн засварын зардалд 2.9 сая төгрөг, цахим тендерийн хураамжийн орлого 70.0 мянган төгрөг зэрэг санхүүжилтийн үлдэгдлээс шалтгаалж нэмэлт санхүүжилтийн дансанд авлага нэмэгдэн үүссэн байна.

Тайлант хугацаанд байгууллагад төлөх өглөг 3.8 сая төгрөгөөр өссөн нь ЗДТГ-ын дотоод засварын ажлын магадалшгүй ажиллагааны зардлын өглөг үүссэн.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлэхээр орон нутгийн төсвөөс 751.1 сая төгрөгийн санхүүжилтийг авч 692.2 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагаанд зарцуулан 58.8 сая төгрөгийг төвлөрүүлэн шилжүүлж ажилсан байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Нийт зардал	3,163,698.2	1,544,335.0	462,345.8	48
2	Урсгал зардал	1,199,209.7	846,942.9	352,266.8	71
3	Бараа ажил үйлчилгээний зардал	1,176,358.9	824,182.3	352,176.6	70
4	Урсгал шилжүүлэг	22,850.8	22,760.6	90	90
5	Хөрөнгийн зардал	1,834,641.1	601,127.1	1,233,514.0	32

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Бүрэгхангай сумын Засаг дарга нь 2022 оны санхүүгийн тайлангаар нэмэлт санхүүжилтийн дансаар 260.7 сая төгрөгийн орлого орж 260.7 сая төгрөгийн зарлага гаргасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

**3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Бүрэгхангай суманд “Хожуул, унанги гишүү” төсөл 1 жилийн хугацаатай нийт 25.0 сая төгрөгийн санхүүжилттэй 95.1 га талбайд байгаль орчны ойн цэвэрлэгээ, шинэ ажлын байр бий болгох, босоо мод унагаахаас сэргийлэх, иргэдэд хэрэглээний модыг бэлтгэн нийлүүлэх зорилготойгоор тус төслийг 2021-2022 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

2022 онд тус төсөлд 5 бүл оролцож гэрээгээр нэг бүлд 5.0 сая төгрөгийн санхүүжилт олгох төлөвлөгөөтэй байсан боловч Байгаль хамгаалах сангаас санхүүжилт нь 15.0 сая төгрөгөөр тавиглаж 5 бүлд 3.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

*Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт*

/мянган төгрөгөөр/						
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	“Хожуул, унанги гишүү” төсөл	1 жил	Байгаль орчны ойн цэвэрлэгээ, шинэ ажлын байр бий болгох, босоо мод унагаахаас сэргийлэх, иргэдэд хэрэглээний модыг бэлтгэн нийлүүлэх	100 хувь биелсэн	25,000.0	15,000.0

Төслийн тайлан мэдээг хавар болон намар төсөл хэрэгжүүлсэн хугацааны биелэлтийг гаргаж Байгаль орчны байцаагч болон сумын Засаг даргын Тамгын газарт тайлагнаж ажилласан байна.

**4. АУДИТЫН ТАЙЛАН**

**4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу

Бүрэгхангай сумын ТТЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Энхтөр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Бүрэгхангай сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дүгээр сарын 01-ний өдрийн 01/82 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүжилтийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүжилтийн дүнгийн 27.2 сая төгрөгөөс 70 хувиар буюу 19.1 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Бүрэгхангай сумын Засаг даргын тамгын газар нь Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага алба хаагчдын хурал цуглаан, сургалт семинарыг цахимаар зохион байгуулж үүнээс албан томилолтын зардлаас 1.2 сая, шатахууны зардлыг өмнөх онтой харьцуулахад 3.3 сая төгрөгийг хэмнэж ажиллажээ.

Соёлын төв нь тус хуультай холбоотойгоор байгууллага алба хаагчдын хурал цуглаан, сургалт семинарыг цахимаар зохион байгуулж үүнээс албан томилолтын зардал, шатахууны зардлыг хэмнэж мөн байгууллагын дотоод сүлжээг ашиглаж байгууллагын бичиг хэргийн зардлыг өмнөх оноос 469.9 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь өмнөх 2021 онд сургууль цэцэрлэгийн үйл ажиллагаа цар тахалтай холбоотойгоор хэвийн бус ажиллаж хоол хүнс 7.7 сая төгрөг, гэрэл цахилгаанд 2.5 сая төгрөг зарцуулсан бол 2022 онд хоол хүнс 42.1 сая төгрөг, гэрэл цахилгаан 5.9 сая төгрөгийн зардал гаргаж өмнөх оноос хоол хүнс 34.4 сая, гэрэл цахилгаан 3.4 сая төгрөгөөр илүү зарцуулсан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд 2022 онд Бүрэгхангай сумын ЗДТГ 7, ИТХ 7, Соёлын төв 7, Ерөнхий боловсролын сургууль 8 мэдээлэл хугацаа хоцроож хуулийн хугацаанд бүрэн мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Зөвлөмж өгөв.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагын жилийн эцсийн төвлөрүүлсэн орлогыг санхүүгийн тайлангаар Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ" 41.2.1 дэх "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" заалтыг мөрлөж ажиллах.

Шийдвэрлэсэн нь:

Зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай мөрдөж ажиллаагүй, нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Бүрэгхангай сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд завсарын аудит хийгээгүй болно.

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Бүрэгхангай сумын Засаг даргын Тамгын газар нь 2022 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 03/313 тоот албан бичгээр акт, зөвлөмжийн хэрэгжилтийн биелэлтийг хүргүүлсэн байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	35,318.7	1	35,318.7	100
Албан шаардлага					
Зөвлөмж	1	0	1	0	100
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>35,138.7</b>	<b>2</b>	<b>35,318.7</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Татварын орлогын төлөвлөгөөг бүрэн төвлөрүүлж ажиллах, орлогыг төлөвлөхдөө статистик тоон үзүүлэлтээр бодитой төлөвлөж батлуулж байх.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 15.8 сая төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрч 15.8 сая төгрөгийн 6 зөвлөмж өгч ажиллаа.

### **5.1 Төлбөрийн акт**

Төлбөрийн акт тогтоогоогүй.

### **5.2 Албан шаардлага**

Албан шаардлага бичигдээгүй болно.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.  
Үүнд:

1. Улсын тэмдэгтийн хураамжтай холбоотой асуудал

Илрүүлэлт: /Нөхцөл байдал, үр дагавар, нийцээгүй хууль тогтоомж, стандартын заалтыг бичих/

1.Улсын тэмдгийн хураамж нь 4,000.0 мянган төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 2,383.9 мянган төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөнөөс 1,616.1 мянган төгрөгөөр тасарсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1, 41.2.1 дэх заалтыг мөрлөж ажиллаагүй.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ" 41.2.1 дэх "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" заалтыг мөрлөж ажиллах.

Илрүүлэлт:

2. Хадгаламжийн хүүгийн орлогыг 35,620.0 мянган төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 29,517.7 мянган төгрөгийг төвлөрүүлж 6,102.3 мянган төгрөгийн төлөвлөгөө тасарсан нь арилжааны банканд дахь иргэдийн хадгаламж буурснаар тасарсан байна.

Өгсөн зөвлөмж:

Орон нутгийн төсвийн орлогыг батлахдаа тооцоолол судалгааг үндэслэж эрсдэл тооцож төлөвлөж байх.

Илрүүлэлт:

3.Ойгоос мод түлээ бэлтгэж ашиглахад 12,369.9 мянган төгрөгөөр төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 5,563.8 мянган төгрөгийг төвлөрүүлж 6,806.1 мянган төгрөгийн албан татвар тасарсан байна.

Өгсөн зөвлөмж:

Орон нутгийн төсвийн орлогыг батлахдаа тооцоолол судалгааг үндэслэж эрсдэл тооцож төлөвлөж байх.

Илрүүлэлт:

4.Түрээсийн орлогыг 3,000.0 мянган төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 1,710.0 мянган төгрөгийг төвлөрүүлж 1,290.0 мянган төгрөгөөр төлөвлөгөө тасарсан байна.

Өгсөн зөвлөмж:

Орон нутгийн төсвийн орлогыг батлахдаа тооцоолол судалгааг үндэслэж эрсдэл тооцож төлөвлөж байх.

Илрүүлэлт:

---

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

5. Албан татварын орлогын төлөвлөгөөг бүрэн төвлөрүүлж ажиллах

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ" 41.2.1 дэх "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" заалтыг мөрдөж ажиллах.

Илрүүлэлт:

6. Нийт 154 мэдээлэл оруулахаас 15 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна

1. ЖДҮ-ийг дэмжих сантай холбоотой асуудал

Илрүүлэлт:

1. Жижиг дүнд үйлдвэрлэлийг дэмжих санаас 2021 онд иргэдээс хандиваар орж ирсэн хөрөнгөнөөс 258.0 мянган төгрөгөөр Өвөрхангай аймаг руу туршлага судлах ажлаар шатахуунд зарцуулсан.

Өгсөн зөвлөмж:

ЖДҮ-ийг дэмжих сангийн хууль журам, тушаал шийдвэрийн хэрэгжилтийг хангаж зориулалтын даргуу зарцуулах

Илрүүлэлт:

2. ЖДҮ-аас 10,022,085 төгрөгийн зээл авсан иргэдийн нэрсийг тодруулж арга хэмжээ авч ажиллах.

Өгсөн зөвлөмж:

ЖДҮ-ийг дэмжих сангийн хууль журам, тушаал шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах

2. ОНХС-тай холбоотой асуудал

Илрүүлэлт:

1. "Ану сервис" ХХК нь цэвэр бохирын шугам тавьж дууссан ч 2022 ондоо багтааж хүлээж аваагүй гүйцэтгэгч компанид 75,000.0 мянган төгрөгийн өглөгийг барагдуулаагүй.

Өгсөн зөвлөмж:

Өглөгийг барагдуулж, цэвэр бохирын шугамыг хүлээлцэх

Илрүүлэлт:

2. "Хос Хас" ХХК-иас ахмадын баярт 12.0 сая төгрөгийн хандив өгөхөөр төлөвлөж байсан ч тухайн үед шилжүүлээгүй тул ОНХС-аас ахмадын баярт шилжүүлж дараа нь М.Батцэнгэл Санхүүгийн албан даргын дансаар дамжуулж нөхөж хийсэн байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;"

Илрүүлэлт:

3. ОНХС-гийн 2022 оны төлөвлөгөөнд тусгагдаагүй Соёлын төвд 1,000,000 төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;"

### 3.ХХС-тай холбоотой асуудал

#### Илрүүлэлт:

1.2017 онд Хоршоо хөгжүүлэх сангаас зээл авсан Дархан багийн иргэн М.Ургаацэцэгийн 713.8 мянган төгрөг, Д.Батбаярын 153.8 мянган төгрөгийн зээлийг хууль хяналтын байгууллагат шилжүүлж төлүүлэх арга хэмжээг авч ажиллах.

#### Өгсөн зөвлөмж:

Зээлийг хууль хяналтын байгууллагат шилжүүлж төлүүлэх арга хэмжээг авч ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Бүрэгхангай сумын ТТЗ	5	15,814.5					5	15,814.5				
ЖДҮ	2	10,280.1					2	10,280.1				
ОНХС	3	87,000.0					3	87,000.0				
СХС	1	867.6					1	867.6				
Дүн	11	113,962.2					11	113,962.2				

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Шилэн данс	1	0					1	0
Дүн								
Нийт дүн	1	10					1	0